

**КИРГИЗИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООН ДАХЬ
ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН
ЗУРАГЛАЛ**

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



**"Хүний эрхийн боловсрол нь
хүний эрхийн зөрчлөөс урт
хугацаанд урьдчилан сэргийлэхэд
нэн чухал хувь нэмэр оруулдаг,
хүн бүрийн бүх эрхийг дээдэлж,
хүндэтгэдэг шударга нийгмийг
цогцлооход чухал хөрөнгө
оруулалт юм".**

НҮБ-ын Хүний Эрхийн
Дээд Комиссарын Газар¹

¹ ohchr.org/en/issues/education/training/pages/hreducationtrainingindex.aspx

АГУУЛГА

1. Оршил	2
1.1 Хүний эрхийн боловсролын олон улсын цар хүрээ	4
1.2 Хүний эрхийн боловсролын хэрэгжилт	5
2. Киргизийн боловсролын тогтолцоо	6
2.1 Эрх зүйн тогтолцоо ба боловсролын тогтолцоо	6
2.2 Киргизийн хүний эрхийн боловсролын тогтолцооны өнөөгийн төлөв байдал	7
3. Хүний эрхийн боловсрол олгоход Киргизд тулгарч буй сорилтууд	10
3.1 Цогц байдлаар хандах хэрэгцээ шаардлага	10
3.2 Шаардлагатай нөөцийн хомсдол	11
3.3 Хичээлийн агуулга, заах арга зүйд тулгарч буй бэрхшээлүүд	12
4. Ахиц дэвшил ба боломжууд	14
4.1 Сурах бичгийн хяналт, үнэлгээ	14
4.2 Багшийн мэргэжил дээшлүүлэх	15
4.3 Иргэний нийгэмтэй хамтран ажиллах нь	15
5. Судалгааны гол үр дүн	18

1. ОРШИЛ

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн нийтлэг соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн аливаа сургалт, боловсрол, мэдээлэл олгох хүчин чармайлт бөгөөд Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааны цөм байсаар ирсэн билээ. Энэхүү зураглал нь Киргизийн албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр Эмнести хэрхэн үйл дүнтэй ажиллаж болохыг тодорхойлох зорилготой юм. Уг зураглал нь доорх үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

1. Өнөөгийн суурь нөхцөл байдал ба сургуулиудад хэрэгжиж буй хүний эрхийн хөтөлбөрүүдийн талаар,
2. Сургуулиудын хүний эрхийн боловсролд тулгамдаж буй өнөөгийн хүндрэл бэрхшээлүүдийн талаар, мөн
3. Киргиз улсын ерөнхий боловсролын хөтөлбөр дэх хүний эрхийн боловсролыг сайжруулах хэрэгцээ, боломжуудыг үнэлэх зэрэг болно.

Энэхүү зураглал нь хамтрагч байгууллагуудтай хийсэн ярилцлага, хамтын ажиллагааны үр дүнд бий болсон юм. Зураглалд хүний эрхийн боловсрол нь олон улсын баримт бичиг, үндэсний боловсролын хөтөлбөрүүд, заах арга зүйн цогц бүрдэл болон практикт хэрхэн тусгагдсан болохыг тайлбарлана. Түүнчлэн, ерөнхий боловсролын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг тусгасан жишээ, чиг хандлага болон голлох оролцогч талуудад тулгамдаж буй сорилтуудыг багтаасан болно. Мөн Киргизийн Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (БШУЯ) болон иргэний нийгмийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны зарим жишээг мөн оруулав.

Ерөнхий хүрээ:

- Боловсролын талаарх олон улсын баримт бичгүүд, үндэсний хууль тогтоомж болон хүний эрхийн агуулга бүхий хичээлийн хөтөлбөрүүд зэргийн хяналт үнэлгээ,
- Батлагдсан боловсролын болон арга зүйн цогц бүрдэл болон шинээр нэвтрүүлж буй арга зүйн тойм,
- Боловсрол, хүний эрхийн чиглэлээр ажилладаг гол хүмүүстэй хийсэн ярилцлага зэргийг багтаасан.

Хүний эрхийн боловсрол нь Эмнести Интернэшнлийн Төв Азийн бүс нутаг дахь үйл ажиллагааны гол чиглэлүүдийн нэг юм. Эмнести нь хүний эрхийн боловсролын чиглэлээр төрийн байгууллагууд, иргэний нийгэм, үндэсний болон олон улсын байгууллагууд, мөн эрдэм шинжилгээний байгууллагуудтай цогц байдлаар хамтран ажилладаг.

Эмнести Интернэшнл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалд заасан хүний эрхийн боловсролын тодорхойлолтыг дагаж мөрддөг (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

2.1 дүгээр зүйл. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний бүхий л эрх, суурь эрх чөлөөг түгээмэл байдлаар хүндэтгэх, мөрдөхөд чиглэсэн төдийгүй хүмүүсийн мэдлэг, ур чадвар, ойлголтоор дамжуулан, өөрийн гэсэн хандлага, зан үйлээр хүний эрхийн зөрчил, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгох, хөхиүлэн дэмжихэд хувь нэмэр оруулах хүртэл тэднийг эрх мэдэлжүүлэх боловсролын, сургалтын, мэдээллийн, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурах бүх үйл ажиллагаанаас бүрдэнэ.

2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь дараах агуулгыг хамардаг:

- a) хүний эрхийн хэм хэмжээ, зарчим, тодорхойлох үнэт зүйлс, хамгаалах механизмийн талаарх мэдлэг, ойлголтыг багтаасан хүний эрхийн тухай боловсрол
- b) сургагч, суралцагч нарын эрхийг нэгэн зэрэг хүндэтгэх замаар сургаж, заадаг онцлогтой хүний эрхээр дамжуулсан боловсрол
- c) өөрийн эрхийг эдлэх, хэрэгжүүлэхийн хамт бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалахад хүмүүсийг мэдэлжүүлсэн хүний эрхэд чиглэсэн боловсролоос бүрдэнэ.²

2019 оноос хойш Эмнести Интернэшнлийн Төв Ази дахь³ хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь Киргиз, Казакстан болон Узбекистан зэрэг улсуудад илүүтэй чиглэх болсон. Одоогийн байдлаар, үндсэн үйл ажиллагаа нь:

- Эмнести Интернэшнлийн жил бүр зохион байгуулдаг “Эрхийнхээ төлөө Бичигцгээ”⁴ захидал бичих кампанит ажлын хүрээнд Киргиз, Казакстан болон Узбекистан улсуудын хүний эрхийн боловсролыг дэмжих,
- Киргиз, Казакстан улсуудын ерөнхий боловсролын хөтөлбөрт хүний эрхийн боловсрол чанартай олгох чиглэлээр оролцогч талуудтай хамтарсан нөлөөллийн стратеги боловсруулах,
- Багш, сургагч, идэвхтнүүдэд Эмнести Интернэшнлийн хүний эрхийн арга зүй, сургалтын материалыг ашиглах, тэдгээрийг сургалтдаа нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэж байна.

Энэхүү зураглал нь Киргиз дахь оролцогч талуудтай хамтран нөлөөллийн стратеги боловсруулахад хувь нэмрээ оруулах юм.

² НҮБ-ын Хүний Эрхийн Боловсрол, Сургалтын тухай Тунхаглал.
https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/hr_education.shtml

³ Зүүн Европ болон Төв Ази дахь хүний эрхийн боловсролын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл Эмнести Интернэшнлийн бүсийн вэб хуудсанд зочилно үү. <https://eurasia.amnesty.org/education/>

⁴ amnesty.org/en/get-involved/write-for-rights/

1.1 Олон улсын хүний эрхийн боловсролын тогтолцоо

Хүний эрхийн боловсрол нь сургалтын хөтөлбөрт сонгон суралцах байдлаар орох ёсгүй. Киргиз нь бусад улс орнуудын нэгэн адил, олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу боловсрол нь хүний эрхийг хүндэтгэн, бэхжүүлэхэд чиглэсэн байх ёстой.⁵

Хүний эрхийн боловсролын хэм хэмжээг тогтоосон олон улсын хэд хэдэн баримт бичгүүд байдгаас гол зарим нэгийг нь Хүснэгт 2-т тусгав.

Хүний эрхийн боловсролын хэм хэмжээг тогтоож буй олон улсын баримт бичгүүдэд: Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (26-р зүйл), Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пакт (13-р зүйл), Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (29-р зүйл), Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах тухай Конвенц (10-р зүйл), Арьс, Үндсээр Алагчлах Үзлийн Бүх Хэлбэрийг Устгах тухай Олон Улсын Конвенц (7-р зүйл), Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Эрхийн тухай Конвенц (8-р зүйл) мөн НҮБ-ын Хүний Эрхийн Боловсрол, Сургалтын тухай Тунхаглал (2-р зүйл) орно.⁶

Тухайлбал, ХЭТТ-ийн 26-р зүйлд “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой”⁷ гэж заасан байдаг.

НҮБ-ын ЭЗНСЭОУП-ын 13-р зүйлийн 1 дэх хэсэгт гишүүн орнууд “хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг” боловсролоор дамжуулан бэхжүүлэх үүрэгтэй болохыг заасан.

1990 онд батлагдсан НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц нь дэлхийн хамгийн олон улс соёрхон баталсан конвенц бөгөөд хүүхдийн боловсрол нь НҮБ-ын Дүрэмд заасан хүний эрх, зарчмуудыг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдэх ёстой хэмээн зааж, дэлхий даяар хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн үндэс суурийг баттай тавьсан юм. Тус конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг НҮБ-ын Хороо нь Конвенцийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан сурч боловсрох эрх нь боловсролын хүртээмж төдийгүй боловсролын агуулгад хамаарах болохыг онцлон тэмдэглэжээ. Үнэт зүйлд суурилсан боловсрол нь хүүхдүүдэд хүний эрхтэй холбоотой орчин үеийн сорилтуудад шийдэл олоход чиглэсэн мэдлэг юм. Түүнчлэн, хүний эрхийг хүндэтгэх үзлийг зөвхөн боловсролын хөтөлбөрийн агуулгаар төдийгүй боловсрол олгох үйл явц, сурган хүмүүжүүлэх арга барил болон сургалтын орчноор дамжуулан төлөвшүүлэх ёстой юм. Суралцах үйл явц нь хүүхдийн эрхэм чанарыг хүндэтгэж, тэдний үзэл бодлоо илэрхийлэх, сургуулийн амьдралд оролцох боломжоор хангах ёстой.⁸

⁵ Эмнести Интернэшнл «Хүний эрхийн боловсрол: Төв Азид хэрэгжүүлэх хүний эрхийн баримт бичиг, механизмын талаар өргөн хүрээнд авч үзэх нь» EUR 04/9074/2018 (2018 оны 09 сарын 11-ний өдөр).
<https://www.amnesty.org/en/documents/eur04/9074/2018/en/>

⁶ <https://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/Compilation/Pages/Listofcontents.aspx>

⁷ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948 (Орос) – <https://www.un.org/ru/universal-declaration-human-rights/index.html>

⁸ НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны Ерөнхий санал зөвлөмж №1, 2001 он, https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CRC%2fGC%2f2001%2f1&Lang=ru

2011 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний Эрхийн Боловсрол, Сургалтын тухай Тунхаглалыг баталж, хүний эрхийн боловсролыг үндэсний боловсролын хөтөлбөртэй нийцүүлэх нэгдсэн тогтолцоог бий болгосон юм. Хүний эрхийн боловсролоор дамжуулан залуусыг чадавхжуулах нь Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны гол хэсэг юм.⁹

1.2 Хүний эрхийн боловсролын хэрэгжилт

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн хэм хэмжээ, зарчим, тодорхойлох үнэт зүйлс болон тэдгээрийг хэрхэн бодитойгоор хэрэгжүүлж, хамгаалах талаар хүмүүст зааж сургах явдал юм. Хүний эрхийн боловсрол нь сургагч, суралцагч нарын эрхийг зэрэг хүндэтгэх замаар сурган заадаг хүний эрхээр дамжуулах боловсролыг хэлнэ. Хүний эрхийн боловсрол нь мөн «хүний эрхийн төлөө суралцах» үзэл санааг чухалчилдаг бөгөөд энэ нь оролцогчдыг өөрсдийн эрхээ эдлэх, хэрэгжүүлэхээс гадна бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалах чадвартай болгоход чиглэдэг. Хүний эрхийн боловсрол нь хүүхэд, залууст хүртээмжтэй байх ёстой бөгөөд сургууль бол уг боловсролыг олж авах гол хэрэгсэл болохыг Нэгдсэн Үндэстний байгууллага тэмдэглэсэн байдаг.¹⁰

Сургуулийн боловсролын тогтолцоо нь хүний эрхийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийг хамгаалах үндсэн механизмуудын талаарх ойлголт өгөх, сурталчлах мөн хүний эрхээ хэрэгжүүлэх ур чадваруудыг зааж сургах замаар хүүхэд, залууст хүний эрхийн мэдлэг олгоход чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Үүний тулд багш нарын мэргэжлийг системтэйгээр дээшлүүлэх, хүний эрхийн салбарт орчин үеийн боловсролын арга зүйг нэвтрүүлэх зэргээр цогц бөгөөд чанартай сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.¹¹

Хүний эрхийн боловсролыг сургуулийн өмнөх боловсрол, бага сургуулиас эхлэн боловсролын бүх түвшинд олгох нь зүйтэй. Ялангуяа хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрөөр олгохын чухлыг Киргиз улс гишүүн орон болох Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) онцлон тэмдэглэсэн байдаг. ЕАБХАБ-ын ЕБС дахь Хүний Эрхийн Боловсролын Удирдамж» нь багш нарын эзэмшсэн байх ёстой үндсэн ур чадвар, сургалтын хөтөлбөр, үнэлгээний аргачлал, багш нарт үзүүлэх дэмжлэг зэрэг хүний эрхийн боловсрол олгоход шаардлагатай цогц мэдээллийг оролцогч улсуудад олгодог. ЕАБХАБ-ын бүс нутгийн түвшинд оролцогч улсууд “сургуулиудад хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах, хамгаалахыг дэмжих болон бүх түвшний суралцагчдад зориулсан хүний эрхийн үр нөлөөтэй сургалтын хөтөлбөрүүд боловсруулах” талаар харилцан тохиролцсон байдаг.¹²

⁹ <https://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/WPHRE/Fourthphase/Pages/FourthPhaseIndex.aspx>

¹⁰ Дэлхийн Хүний Эрхийн Боловсролын Хөтөлбөр. НҮБ-ын ХЭДКГ, 2005 он.
https://www.ohchr.org/Documents/Publications/ThirdPhaseWPHREducation_RU.pdf

¹¹ Амнести Интернэшнл хүний эрхийн үнэт зүйлс, зарчмыг сургуулийн амьдралын бүхий л түвшинд буюу сургуулийн орчинд буй бүх хүмүүс хүний эрхийн талаар суралцаж, зааж, хэрэгжүүлж, хүндэтгэж, хамгаалж, сурталчилж байх зорилго бүхий «Хүний Эрхэд Ээлтэй Сургууль» төслийг хэрэгжүүлсэн. <https://www.amnesty.org/en/human-rights-education/human-rights-friendly-schools/>

¹² ЕАБХАБ-ын ЕБС-д зориулсан Хүний Эрхийн Боловсролын Удирдамж. <https://www.osce.org/files/f/documents/c/5/97574.pdf>

2. КИРГИЗИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

Киргиз улсын Боловсролын тухай хуульд¹³ боловсрол нь “төрийн бодлогын стратегийн тэргүүлэх салбар” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь ХЭТТ зэрэг олон улсын баримт бичгүүдэд тусгасан зарчмуудад суурилсан ба НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтууд¹⁴ болон Бүх Нийтийн Боловсролын хөтөлбөрүүдийн¹⁵ зорилгуудыг биелүүлэхэд чиглэдэг. Засгийн газраас боловсролын чиглэлээр 2012-2020 онд баримтлах стратегийн хүрээнд тавьсан алсын хараа нь “бие даан ажиллах мөн харилцааны өндөр ур чадвартай, үзэл бодлоо нээлттэй илэрхийлдэг, бүтээлч, шинэлэг арга барил хандлагатай, хүний эрх, эрх чөлөө, жендэрийн тэгш байдлын үнэт зүйлсийг хуваалцдаг, соёл, үндэстэн, ястны болон улс төрийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг иргэдийг бэлтгэх боловсролын системийг бий болгох”¹⁶ зорилт тавьсан байна.

2.1 Эрх зүйн үндсэн зохицуулалт ба сургуулийн тогтолцоо

Киргиз улсын боловсролын салбарыг зохицуулдаг үндсэн эрх зүйн баримт бичгүүд нь Киргиз улсын Боловсролын тухай хууль¹⁷, Хүртээмжтэй Боловсролыг Хөгжүүлэх Хөтөлбөр 2019-2023,¹⁸ 2014 оны 7 сарын 21 өдрийн 403 тоот тогтоолоор батлагдсан Киргиз улсын Ерөнхий Боловсролын Үндэсний стандарт,¹⁹ 2012-2020 оны Боловсролын стратеги, Хэрэгжүүлэх Үйл ажиллагааны Төлөвлөгөө²⁰ болон Киргиз улсын боловсролын байгууллагуудын сургалтын үндсэн хөтөлбөрүүд²¹ зэрэг юм.

Эдгээр баримт бичгүүдэд зааснаар сургуулийн тогтолцоо нь боловсролын тогтолцооны гол холбоос бөгөөд хувь хүнд чиглэсэн хандлагад тулгуурлан, суралцагч бүрт тодорхой нэг сэдэв эсвэл чадамжуудыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн байдаг. Суурь боловсрол нь бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол болон хөдөлмөрийн зах зээлд гарах үндэс суурийг бүрдүүлдэг. Бүрэн дунд сургуулийн боловсрол нь төгсөгчдийн хувь хүний болон нийгмийн дасан зохицох чадварыг сайжруулж, дунд сургууль эсвэл дээд боловсролын байгууллагад үргэлжлүүлэн суралцах, эсвэл хөдөлмөрийн зах зээлд шилжих боломжийг олгодог.

¹³ Киргиз улсын Боловсролын тухай хууль. – <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/1216?cl=ru-ru#:~:text=Закон%20КР%20от%2030%20апреля%202003%20года%20№%2092%20%2206%20образования%22&text=Настоящий%20Закон%20устанавливает%20принципы%20государственной,служит%20правовой%20базой%20их%20реализации>

¹⁴ НҮБ-ын Мянганы Тунхаглал. ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/Millennium.aspx

¹⁵ Бүх Нийтийн Боловсролын Төлөө 2015, Бид чадах уу? Дэлхийн Боловсролын Хяналт үнэлгээний тайлан. (unesco.org)

¹⁶ Киргиз улсын Боловсролын Хөгжлийн Стратеги (2012-2020) Планиполис (unesco.org)

¹⁷ Киргиз улсын Боловсролын тухай хууль. edu.gov.kg/ru/docs/zakon-kr-ob-obrazovanii/

¹⁸ Киргиз улсын 2019-2023 онд хэрэгжүүлэх Хүртээмжтэй боловсролын үзэл баримтлал. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/14591>

¹⁹ Засгийн газрын 2014 оны 7 сарын 21 өдрийн тогтоол. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/96690>

²⁰ 2012-2020 онд Боловсролын талаар баримтлах стратеги төлөвлөгөө. 014 <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/96690>

²¹ Боловсролын Яамны тушаалын хавсралт. <https://edu.gov.kg/ru/schools/school-books/prilozhenie-k-prikazu-moin-kr/>

Сургууль нь боловсролын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гурван үе шаттай байдаг:

- Бага сургууль 1-4-р анги хүртэл
- Дунд сургууль 5-9-р анги хүртэл Бүрэн дунд боловсролыг 11 жилийн хугацаанд эзэмшдэг.
- Бүрэн дунд сургууль 10-11 анги хүртэл.

Киргиз улсад төрийн, орон нутгийн/хотын болон хувийн хэвшлийн дунд сургуулиуд байдаг. Тэдгээрийг ерөнхий боловсролын сургууль, гимнази болон лицей гэж ангилдаг. Тус улсад одоогийн байдлаар киргиз, орос, узбек, тажик гэсэн 4 хэлээр хичээл заадаг нийт 2197 сургууль²² байна. Удирдлага, өмчийн хэлбэр, сургалтын хэл зэргээс үл хамааран ЕБС-ууд нь улсын боловсролын стандарт, хичээлийн стандарт болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.2 Киргизийн хүний эрхийн боловсролын тогтолцооны өнөөгийн төлөв байдал

Эмнести Интернэшнлээс хийсэн судалгаагаар Киргиз улсын албан боловсролд хүний эрхийн боловсролын нэгдсэн тогтолцоо байхгүй байгааг тогтоосон. Үүнд олон улсын хэм хэмжээнд нийцсэн хүний эрхийн үндэсний сургалтын хөтөлбөр, хүний эрхийг заах сургалтын багц (гэхдээ, үүгээр хязгаарлагдахгүй), багш нарт зориулсан мэргэжлийн сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд (эсвэл заах ур чадварыг тогтмол хянах, үнэлэх хөтөлбөр гэх мэт) зэрэг багтана.

Практикт Киргизийн сургуулиуд хүний эрхийн боловсролыг ерөнхийдөө “Хүн ба Нийгэм” хичээлийн агуулгаар олгодог бөгөөд ижил нэртэй сэдвийн хүрээнд хичээлээ заадаг.

Дунд сургуулийн 5-9 дүгээр ангийн суралцагчдад зориулсан “Хүн ба Нийгэм” хичээлийн стандартыг 2018 онд баталсан бөгөөд Киргиз улсын Боловсролын тухай хууль болон Засгийн газрын 403 дугаар тогтоол буюу Ерөнхий Боловсролын Стандартад үндэслэн боловсруулсан байна. Энэ нь тухайн хичээлийн хүрээнд улсын хэмжээнд дагаж мөрдөх наад захын агуулга болон суралцагч, төгсөгчдийн эзэмшвэл зохих түвшний шаардлагыг тогтоож өгдөг.²³ “Хүн ба Нийгэм” нь хувь хүний нийгэмд болон дэлхий нийтэд эзлэх байр суурь, хүн хоорондын болон төр, олон нийтийн байгууллага хоорондын харилцааны талаар практикт суурилсан хичээл юм. Уг хичээлийн стандартын тэргүүлэх чиглэлд Киргизийн ард түмний эв нэгдэл, ардчилсан үзэл, иргэний эрх үүрэг, соёл болон бусад олон талт байдал зэргээс гадна хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголтыг багтаажээ.

²² Киргиз хэлээр хичээл ордог 1410, орос хэлээр хичээл ордог 201, узбек хэлээр хичээл ордог 121, тажик хэлээр хичээл ордог 3, олон хэлээр хичээл ордог 462 сургууль байна. Боловсрол дах хэлний бодлого: Киргизийн өмнөд хэсгийн олон хэлний боловсролын хэтийн төлөв ба нийгмийн хэрэгцээ шаардлага – тайланг үз. https://soros.kg/srs/wp-content/uploads/2019/08/policy_brief_center_social_integration.pdf

²³ 5-9 дүгээр ангийнханд зориулсан «Хүн ба Нийгэм» хичээлийн стандарт. <https://edu.gov.kg/media/files/9e240494-01c7-4413-8e46-9e93e4fc5689.pdf>

Хичээлийн стандартад тухайн хичээлээр олгох үндсэн ойлголт, заах арга зүй, хүлээгдэж буй үр дүн, суралцагчдын мэдлэг, ур чадварыг хэрхэн үнэлэх талаар нарийн заасан байдаг. Энэ хүрээнд суралцах үе шатыг 3 түвшинд хувааж үздэг:

1-р шат

(1-4 дүгээр анги)

өөрийгөө илэрхийлэх ур чадвар, хүмүүсийн адил төстэй болон ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэгш байдлын талаар суралцах, хүний эрхийн үндсэн ойлголт, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх хэрэгцээ шаардлагын талаар ухамсарлах,

2-р шат

(5-9 дүгээр анги)

энэ шатанд илүү нарийн төвөгтэй асуудалд анхаарлаа хандуулахад суралцана. Тухайлбал, зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг шийдвэрлэх ур чадварт суралцах, бусадтай ялгаварлахгүйгээр харилцаа тогтооход суралцах, нийгмийн амьдралд оролцохдоо хүлээцтэй байх зан төлөвийг төлөвшүүлж, хөгжүүлэх,

3-р шат

(10-11 дүгээр анги)

Киргиз улсын ардчиллыг бэхжүүлэхэд шаардлагатай мэдлэгийг залууст эзэмшүүлэх, суралцагчдын дунд идэвхтэй иргэний байр суурийг бий болгох, хариуцлагыг төлөвшүүлэх, зөв харилцааны арга барилд сургах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, иргэд, нийгэм, төр хоорондын харилцааны талаар ойлголтыг бий болгох²⁴.

Хичээлийн стандартыг түүх, газарзүй, уран зохиол, математик, физик зэрэг бусад хичээлүүдтэй хэрхэн уялдаа холбоотой болохыг чанартайгаар тайлбарласан боловч хэлний хичээлүүдтэй (киргиз, орос, англи болон бусад) уялдаа холбоог дурдаагүй байна. Хичээлийн стандарт нь багш нарт хичээлийн сэдвийн агуулгын цаадах логик холбоог дэлгэрэнгүй заасан байдаг. Стандарт нь багш нарт тухайн хичээлийг янз бүрийн арга зүй ашиглан заах боломжийг олгодог. Жишээ нь:

- Сурах бичиг, цахим сурах бичиг, аппликэйшн, тухайн хичээлийн хүрээнд хэрэглэж болох сургалтын болон арга зүйн ном, гарын авлагууд,
- Тухайн сэдвээрх хэвлэмэл материал, интернет дэхь цахим эх сурвалжууд.

Хичээлийн стандартад “Хүн ба Нийгэм” хичээлийн ерөнхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарт тавигдах үндсэн шаардлагыг мөн тодорхойлсон байна. Үүнд:

- Тухайн багшийн боловсрол эзэмшсэн байдал, нас, хувийн зан чанар, хөгжлийн хүчин зүйлс,
- Суралцагчдын эрх, эрх чөлөөг хангах, тэдэнд нийгмийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чадвартай байх,

²⁴ 10-11 дүгээр ангийнханд зориулсан «Хүн ба Нийгэм» хичээлийн стандарт.
http://lib.intuit.kg/wp-content/uploads/2019/11/%D0%A7%D0%B8%D0%9E-10-11-%D0%BA%D0%BB_rus.pdf

- Заах арга зүйн талаар системтэй мэдлэгтэй байх, орчин үеийн сэтгэл зүй, заах арга зүйн болон боловсролын хөгжлийн технологийн талаарх мэдлэг, ойлголттой байх,
- Суралцагчдад зориулсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах чадвартай байх,
- Боловсролын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтын талаарх мэдлэгтэй байх,
- Боловсролын салбарт туршилт, судалгаа хийж байсан туршлагатай байх,
- “Хүн ба Нийгэм” хичээлийг орчин үеийн, олон төрлийн заах арга зүй ашиглан хэрхэн үр дүнтэй заах талаарх мэдлэг, ойлголттой байх,
- “Хүн ба Нийгэм” хичээлээр төрөлжсөн сургалт явуулах, зохиогчийн хөтөлбөр боловсруулахад хувь нэмрээ оруулах чадвартай байх.

“Хүн ба Нийгэм” хичээл нь²⁵ сургалтын хөтөлбөрт заавал байх ёстой ба сургалтын үр дүнтэй холбоотой хичээлийн стандартын шаардлагын хамт ерөнхий боловсрол олгодог сургалтын бүх байгууллагуудад тохиромжтой. 5-9 дүгээр ангид дараах агуулгаар хичээл орно:

5-р ангид - Хувь хүн ба гэр бүл найз нөхөд, сургууль гэх мэт ойрын хүрээллийн тухай...

6-р ангид - Хувь хүн ба тэдний нийгэм болон ойр орчмын хөршүүдтэйгээ хэрхэн харилцах тухай...

7-р ангид - Хувь хүн, нийгэм ба төр хоорондын харилцаа

8-9 дүгээр ангид - Хувь хүн ба дэлхий ертөнц хоорондын харилцааны тухай.

Албан боловсролын хөтөлбөрт хүний эрхийг зөвхөн “Хүн ба Нийгэм” хичээлээр заадаг. Энэхүү хичээл нь нийгэмших, үйл ажиллагаа болон хууль тогтоомж гэсэн 3 үндсэн сэдвээс бүрдэх бөгөөд хүний эрх, эрх чөлөө нь гол агуулга болдгийг тэмдэглэх нь зүйтэй.

²⁵ 5-9 дүгээр ангийнханд зориулсан «Хүн ба Нийгэм» хичээлийн стандарт.
<https://edu.gov.kg/media/files/9e240494-01c7-4413-8e46-9e93e4fc5689.pdf>

3. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХОД КИРГИЗ УЛСАД ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ

Бүгд Найрамдах Киргиз улсын Боловсролын тухай хуульд боловсролд хүний эрхийн ойлголтын ач холбогдлыг тодорхой тусгасан²⁶ бөгөөд Боловсрол, Шинжлэх Ухааны Яамнаас суралцагчдад хүний эрхийн онолын тодорхой мэдлэг ойлголт өгөхийн тулд хичээлийн хөтөлбөрийн чанарыг сайжруулахаар иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Гэхдээ Киргизийн хүний эрхийн боловсролыг засгийн газрын алсын хараа болон олон улсын жишигт нийцүүлэхэд сорилтууд тулгарсаар байна. Үүнд хэрэглэхэд бэлэн, агуулгын хувьд тохиромжтой сурах бичиг дутмаг бөгөөд киргиз хэл дээр нээлттэй мэдээлэл авах боломжтой хүний эрхийн эх сурвалж хомс байгаа нь хүний эрхийн боловсролын тогтолцоо сайн бүрдээгүй байгааг илтгэнэ. Орон нутгийн оролцогч талуудын зүгээс зарим эцэг, эхчүүд жендэрийн тэгш байдал зэрэг хүний эрхийн тодорхой асуудлыг сургуульд заахыг эсэргүүцдэг гэх мэт хүний эрхийн зарим үзэл баримтлалтай холбоотой бэрхшээл тулгардаг талаар дурдаж байв.²⁷

3.1 Цогц байдлаар хандах хэрэгцээ шаардлага

Багш, суралцагчдын аль алины хүний эрхийг хүндэтгэсэн, дэмжсэн, хамгаалсан сургуулийн орчныг бүрдүүлэхэд хичээлийн хөтөлбөр дангаараа хангалтгүй. Багш, суралцагчид хүний эрхийн талаар мэддэг, хамгаалдаг, хүндэтгэдэг байхын тулд сургуулиуд хүний эрхийг дэмжих олон талт оролцоонд суурилсан тогтолцоог бий болгох шаардлагатай. Ийм цогц хандлага нь хүний эрхийн практик туршлагаар дамжуулан хүний эрхийн талаар суралцах боломжтой орчныг бүрдүүлдэг.

БНКУ-ын Боловсролын Санаачилгыг Хөгжүүлэх Сан ТББ-ын ажилтан Татьяна Матокхина дараах байр суурийг илэрхийлэв:



“Хүний эрх, ялгаварлан гадуурхахгүй байх, хүртээмжтэй байдал зэрэг сэдвүүдээр мэдрэмжтэй хандах тал дээр яамтай бүх түвшинд хамтарч ажиллаж эхлэх нь чухал байна. Сургуулийн орчин дахь хүний эрхийн хэрэгжилтийг дан ганц хичээлээр хангаж чадахгүй. Боловсролын систем бүхэлдээ, бүх хичээлийг заахдаа, сургалтын байгууллагууд өөрсдөө санаачлан хөгжүүлэхдээ, сургуулийн түвшинд

²⁶ БНКУ-ын Боловсролын тухай хууль. <https://edu.gov.kg/ru/docs/zakon-kr-ob-obrazovanii/>

²⁷ 2020 оны 3-6 сард Эмнести Интернэшнлээс хамтрагч байгууллагуудтай Зүүмээр хийсэн ярилцлагууд.

хүний эрхийн чиглэлээр төсөл, судалгааны үйл ажиллагаа явуулахдаа цогц байдлаар хандах шаардлагатай байна. Сургуулийн захирал, дэд захирал, нийгмийн ажилтан зэрэг ажилтнууд, эцэг, эхийн зөвлөлийн гишүүд, сургуулийн зөвлөлийн гишүүдэд зориулсан мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах хэрэгтэй. Сургуулийн стратеги төлөвлөгөөнд хүний эрхийн үнэт зүйлсийн талаар тусгах нь энэ чиглэлийн үйл ажиллагааны бодит үр дүн байх болно гэж бодож байна”.

”

3.2 Шаардлагатай нөөцийн хомсдол

Энэхүү судалгаанд оролцогчид чанартай сурах бичиг хангалтгүй байгаагаас сургуулийн бүх ангид “Хүн ба Нийгэм” хичээлийг заахад бэрхшээл тулгардаг талаар олонтаа дурдсан юм. Сурах бичгүүдэд ялгаатай байдал, хүлцэхүйн талаар хүний эрхийн мэдрэмжтэй агуулга байдаггүйгээс гадна хүний эрхийг хамгаалах, дэмжих талаар бодитой мэдлэг, ойлголт тусгаагүй. Үүний улмаас сурах бичиг нь одоо хүртэл боловсруулалтын шатандаа байгаагаас 7-8 дугаар ангийнхан уг хичээлийг судалж чадахгүй байна. Киргизийн Залуучуудын Хөгжлийн Төв ТББ-ын захирал Азхара Казималиева хэлэхдээ

“

“Жишээ нь, “Хүн ба Нийгэм” хичээлийг 5-11 дүгээр ангид заах ёстой ч амьдрал дээр зөвхөн 5-6 болон 9-11 дүгээр ангиудад зааж байна. 7-8 дугаар ангид заах хичээлийн агуулгыг боловсруулаагүй байгаагаас энэ ангиудад хичээл орж чадахгүй байна” гэжээ.

”

Бусад ангиудад чанарын шаардлага хангасан сурах бичиг дутагдалтай байна. Тухайлбал, 2018 онд О.Осмоновын зохиосон 5-6 дугаар ангийн “Хүн ба Нийгэм” хичээлийн сурах бичиг хичээлийн стандарттай нийцээгүй учир ихээхэн шүүмжлэлд өртсөн. Сурах бичгийг хянаж сайжруулах зорилготой тусгайлсан ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны яам байгуулсан.²⁸ Үүнээс болж сургуулиуд бүтэн жил сурах бичиггүй байжээ. Дэлхийн Банк болон Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд дээрх сурах бичгийг боловсруулах ажилд оролцсон ажээ. 9-11 дүгээр ангийн “Хүн ба Нийгэм” хичээлийн сурах бичгийг шинэчлэн сайжруулаагүй бөгөөд уг хичээлээр олгох ёстой агуулгыг бусад хичээлүүдэд шингээсэн.

“

“2015 онд Киргизийн Хүн амын Эрх зүйн Соёлыг 2016-2020 онд хөгжүүлэх Хөтөлбөр”-ийг боловсруулан баталсан. Улмаар бага, дунд ангид заах “Хүн ба Нийгэм” хичээлийн сурах бичгийг боловсруулах, хөгжүүлэхэд гол хөшүүрэг

²⁸ «Хүн ба Нийгэм» хичээлийн сурах бичиг. 6-р анги. <https://www.kitep.edu.gov.kg/ru/view/41>

болсон юм.²⁹ 2018 оноос өмнө, уг хичээлийг зөвхөн 9-11 дүгээр ангид заадаг байсан. Цаашлаад, 2020 оноос эхлэн “Хүн ба Нийгэм” хичээлийн агуулгыг 9-11 дүгээр ангийн Нийгэм, Эдийн засгийн үндэс, Ёс зүйн хичээлүүдэд хуваан шингээсэн. Хичээлийн цаг нэмэгдээгүй ч хичээлүүдийг нэгтгэсэн шалтгаан нь 9-11 дүгээр ангийн сурагчдын ачааллыг бууруулах зорилготой байсан юм” гэж Азхара Казималиева онцолжээ.

”

Түүнчлэн, багш нар киргиз хэл дээрх хүний эрхийн арга зүйн эх сурвалжуудийг нээлттэй платформоос олоход бэрхшээлтэй тулгардаг. Ковид-19 цар тахлын улмаас Киргиз улсад чанартай зайны сургалтын шинэ арга хэрэгсэл бий болгоход улам хүндрэлтэй болгожээ. Гэхдээ Боловсролын Санаачилгыг Дэмжих Сангийн зохицуулагч Татьяна Маткхинагийн хэлснээр, “Коронавирус цар тахлын улмаас тулгарсан сорилтуудыг даван туулахын тулд Боловсрол, Шинжлэх Ухааны Яам чанартай, хүртээмжтэй, зайны боловсролыг хөгжүүлэх шинэ арга хэрэгслүүдийг ашиглахад илүү нээлттэй болсон”.

3.3 Хичээлийн агуулга, заах арга зүйд тулгарч буй бэрхшээлүүд

Багш нарын хувьд уг хичээлийн стандартад туссан агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг гэжээ. Азхара Казималиевагийн хэлснээр,

“

“Хүн ба Нийгэм” хичээлийн стандарт нь үзэл баримтлалын хувьд маш сайн боловч³⁰ харамсалтай нь олон багшид стандарттай танилцах, заавал хамрагдах ёстой шинэчилсэн агуулгын сургалтуудад суух цаг зав байдаггүй учраас Боловсролын яамнаас баталж өгсөн хөтөлбөрийг л дагаж, хичээлээ заадаг. Стандартыг 5 жил тутамд шинэчилдэг бөгөөд 2020 онд дахин шинэчлэх ёстой.

”

Хичээлүүдийг нэгтгэхдээ, багш нарын чадавх болон мэргэшсэн байдлыг нь анхаарч үздэггүй. Жишээ нь, “Хүн ба Нийгэм”-д туссан эдийн засагтай холбоотой агуулгыг энэ сэдвээр бэлтгэгдээгүй түүхийн багш орж байна. Гэхдээ, Мэргэжлийн Хөгжлийн Институтаас багш нарыг одоогийн хичээлийн стандарттай танилцуулах, багш нарт холбогдох мэдээллийг өгөхөд зориулсан онлайн хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулах зэргээр дэвшил гаргаж байна.”

²⁹ БНКУ-ын хүн амын эрх зүйн соёлыг 2016-2020 онд сайжруулах хөтөлбөрийн үзэл баримтлал. <http://minjust.gov.kg/ru/content/753>

³⁰ 5-9 дүгээр ангид зориулсан «Хүн ба Нийгэм» хичээлийн стандарт. <https://edu.gov.kg/media/files/9e240494-01c7-4413-8e46-9e93e4fc5689.pdf>



Үүнээс гадна, хүний эрхийг “иргэний үүрэг”, “хууль ба дүрэм журам” болон “зүй бус” зан авир гэх мэт ойлголтуудын хооронд хольж, төөрөгдөж байгааг судалгаанд оролцогчид онцолж байв. Ер нь Киргизийн хувьд хөдөө орон нутагт хүний эрхийн зарим үзэл баримтлалыг Барууны, Европын үзэл санааг гэж үздэг байна. Орон нутгийн нэг оролцогчийн хэлснээр,

“

“Багш нар нь сурагчдад хүний эрхийн талаар заах чадвартай байлаа ч ялгаатай байдал, бэлгийн боловсрол олж авах эрх, жендэрийн тэгш байдал зэрэг сэдвүүдийг хөндөх юм бол хүүхдэд нь гэр бүлийн үнэт зүйлтэй нийцэхгүй муу/хүлээн зөвшөөрөшгүй зүйл заасан гэж багшийг буруутгаж болзошгүй”.

”

Иймээс хүний эрхийн боловсролд ХЭТТ-ын болон олон улсын хүний эрхийг хамгаалах тогтолцооны нийтлэг үнэт зүйлсийг онцолж оруулах нь зүйтэй.

4. АХИЦ ДЭВШИЛ, БОЛОМЖ

Эмнести Интернэшнлийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагуудаас үзэхэд төрөөс боловсролын чанарыг сайжруулахын тулд сургалтын материалыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх, багш нарыг чадавхжуулах зэргээр олон хүчин чармайлт гаргаж байна. Түүнчлэн, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар сургуулиудад хүний эрхийн үзэл санааг дэлгэрүүлэх боломжууд цаашид ч бий.

4.1 Сурах бичгийн хяналт, үнэлгээ

Боловсролын яамнаас Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийг баримтлан 2018 онд сурах бичгүүдийн ялгаварлан гадуурхахгүй байх болон жендэрийн агуулгын талаар үнэлгээ хийсэн. Тус хуульд хүйс, үндэс угсаа, хэл, нийгмийн болон эд хөрөнгийн байдал, хөгжлийн бэрхшээл, ажил мэргэжлийн төрөл, хэлбэр, шашин шүтлэг, улс төрийн болон оршин суугаа газар болон бусад нөхцөл байдлаас үл хамааран сурч боловсрох эрхийг баталгаажуулсан байдаг. Мэргэжилтнүүдийг баг 1-10 дугаар ангийн 40 сурах бичигт үнэлгээ хийжээ.

Нийгмийн Технологийн Төв байгууллагын захирал Зулфияа Кочорбаевагийн дүгнэж хэлснээр *“Сурах бичгүүдийн үл ялгаварлан гадуурхах болон жендэрийн агуулгыг дараах шалгууруудаар үнэлсэн: хүйсийн илэрхийлэмж, жендэрийн онцлог байдлууд, гэр бүлийн үүрэг, хариуцлагын хуваарилалт, нийгмийн үүргийн хуваарилалт, ажил, мэргэжил, угсаатны болон эмзэг бүлгийнхний төлөөлөл, ялгаварлан гадуурхалт болон тэгш бус байдал, дайн, мөргөлдөөн болон олонхийг хамарсан хүчирхийлэл зэрэг болно. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд сурах бичгүүд нь жендэрийн хэвшмэл ойлголтод суурилсан агуулгатай ба угсаатны төлөөллийг оролцуулаагүй, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар дурдаа ч үгүй болохыг харууллаа. Сургалтын материал хязгаарлагдмал бөгөөд нэр томьёог киргиз, узбек, тажик хэл рүү орчуулахад бэрхшээлтэй байв.”*

2021 онд Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний чанарын асуудлыг хариуцсан “Окуу Кибэти” хэмээх Сургалт, судалгааны төвийг байгуулжээ. Тус төвийн зорилго нь³¹:

1. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний чанарыг сайжруулах,
2. Сурах бичиг зохиогчид, тэдний ур чадварын талаар мэдээллийн сан үүсгэх,
3. Сурах бичигт үнэлгээ хийдэг мэргэжилтнүүд, тэдний сургалт, гэрчилгээ олгосон байдлын талаар мэдээллийн сан үүсгэх,
4. Сурах бичгийг шинэчлэх хэрэгцээ шаардлагыг судлах,
5. Суралцагчдыг орчин үеийн, чанартай, алдаагүй сурах бичгээр хангах,
6. Цахимжих үйл явцын нэг хэсэг болох цахим сурах бичгүүдийг бэлтгэх,

³¹ «Окуу Китеби» Сургалт, Судалгааны Төв. <http://kao.kg/издательский-центр-окуу-китеби/>

7. Зохиогчид болон хэвлэн нийтлэгчдийн бэлтгэсэн сурах бичигт дөрвөн төрлийн үнэлгээ хийх, үүнд:

- Шинжлэх ухааны үнэлгээ
- Заах арга зүйн үнэлгээ
- Үл ялгаварлан гадуурхах болон жендэрийн агуулгын үнэлгээ
- Хэрэгжүүлэх боломжийн үнэлгээ зэрэг болно.

4.2 Багш нарын сургалт

Боловсролын тухай хуульд зааснаар багш нар БШУЯ-ны харьяа Багшийн Мэргэжлийн Хөгжил, Сургалтын Хүрээлэнд таван жил тутамд ахисан түвшний сургалтанд хамрагдах ёстой. Тус Хүрээлэнгийн Заах арга зүй, Сэтгэл зүй, Нийгэм-Хүмүүнлэгийн Тэнхимийн багш Матлюба Латиповна Азимовагийн хэлснээр,



“Хүн ба Нийгэм” хичээлийг 5-6, 9-11 дүгээр ангиудад заадаг. Багш нар тус хүрээлэнгийн хөтөлбөрөөр дамжуулан хүний эрхийн орчин үеийн хандлага болон бусад шинэлэг мэдлэг, мэдээллийг олж авдаг. Жишээ нь, 2019 онд Боловсролын Санаачилгын Дэмжлэг байгууллагатай хамтран бид үл ялгаварлан гадуурхах болон жендэрийн агуулгаар хоёр модуль боловсруулсан.³² Багш нар уг модулийг онлайнаар суралцаад, гэрчилгээ авах боломжтой.³³



4.3 Иргэний нийгэмтэй хамтран ажиллах нь

Иргэний нийгмийн байгууллагууд БШУЯ-тай богино болон урт хугацаанд хамтран ажиллах санамж бичиг байгуулах боломжтой. Энэ нь сургуулийн орчинд багш, сурагчдад хүний эрхийн албан бус боловсрол олгох үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх боломжийг нээж өгнө.³⁴

Гэсэн хэдий ч хамтрагчдаа сонгоход болгоомжлох, хүнд суртал, ажилтнууд өөрчлөгдөх зэргээс шалтгаалан гэрээний хэрэгжилт удааширах зэрэг нь урт хугацааны төлөвлөлт хийх чадварт сөргөөр нөлөөлөх зэргээр сорилтууд тулгарсаар байна. Тухайлбал, БШУЯ хамтран ажиллах түншээ сонгохдоо олон нийтийн, эцэг эхчүүдийн эсэргүүцэлтэй тулгарахгүйн тулд ихээхэн болгоомжтой ханддаг. Эмнеститэй ярилцсан нэг хүний хэлснээр “иймэрхүү хандлага нь Нөхөн үржихүйн эрүүл мэндийн холбооноос гаргасан бэлгийн болон нөхөн

³² Багш нар сургуульдаа ялгаварлан гадуурхахгүй байх болон жендэрийн тэгш байдлын талаарх зарчмуудыг нэвтрүүлж байна. <https://kyrgyzstan.un.org/ru/48913-uchitelya-vnedryayut-principy-gendernogo-ravenstva-i-nediskriminacii-v-shkolnoe-obrazovanie>

³³ Сургуулийн орчинд ялгаварлан гадуурхахгүй байх ба жендэрийн тэгш байдлыг хангах нь. <http://grn.ripk.kg/ru/books/2/intro>

³⁴ Олон нийтийн байгууллагууд, Сангууд болон Төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны үзэл баримтлалд үндэслэн, <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/55210>

үржихүйн эрүүл мэндийн тухай тараах материалуудтай холбоотой хэд хэдэн асуудал гарсан холбоотой байж болзошгүй.

Эцэг, эхчүүд хүүхдүүддээ ийм төрлийн мэдээлэл өгөхийг зохисгүй гэж үзэж гомдол гаргасан юм. Түүнчлэн, Засгийн газрын 2017-2022 онд хэрэгжүүлэх Терроризм, Экстремизмтэй тэмцэх байгууллагуудыг чадавхжуулах үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой байж болох юм”.³⁵

БШУЯ-ны албан тушаалтнууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахад нээлттэй байдаг талаар судалгаанд оролцогчид дурдаж байв. Гэхдээ санамж бичгийн төсөл боловсруулах, гарын үсэг зурах зэрэгт ямар хугацаа шаардагдах нь тодорхойгүй тул хамтын ажиллагааг ажил хэрэг болгоход удаашралтай. Түүнчлэн, Киргизийн улс төрийн тогтворгүй байдал, яамдын сайд нар, хэлтсүүдийн ажилтнууд байнга солигддог нь урт хугацаанд төсөл хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсгэдэг ба тухай бүр шинэ хүнтэй нүүр тулж, хамтын ажиллагааг дахин эхлүүлэх шаардлагатай болдог.

4.3.1. Иргэний нийгэм хүний эрхийн боловсролыг түгээгч болох нь

Иргэний нийгмийн янз бүрийн байгууллагуудаас олгодог ЕБС-ууд руу чиглэсэн хүний эрхийн боловсролыг энэ судалгаанд оруулаагүй. Гэхдээ Киргиз улсад ийм үйл ажиллагаа түгээмэл байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Дор зарим нэг жишээ оруулав. Киргизийн төрийн байгууллагууд мэргэжлийн боловсрол олгодог лицей сургуулиудтай хамтран ажилладаг. Жишээ нь, АИДИА Төв Ази ТББ-аас тэдгээр мэргэжлийн боловсролын лицей сургуулийн багш нарт зориулсан сургалтын гарын авлага, иргэний чадамжийн үнэлгээний систем, суралцагчдад зориулсан “Мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин” сургалтын материал боловсруулж өгсөн байна.³⁶ Энэхүү гарын авлагыг багш нарын мэдээллийн технологийг илүүтэй ашиглах явдлыг дэмжих зорилгоор интерактив хэлбэрээр бүтээжээ. Тус байгууллагын хөтөлбөрийн ажилтан Айзат Руслановагийн хэлснээр

“

“Киргизийн мэргэжлийн боловсролын лицей сургуультай ажиллах нь ерөнхий боловсролын сургуультай ажиллахаас илүү хялбар байсан. Учир нь мэргэжлийн боловсролын лицей сургуулийн захиргаа нь сургалтын хөтөлбөрөө өөрсдөө тодорхойлдог бөгөөд багш, сурагчдад зориулсан сургалтын материал бэлтгэхэд иргэний нийгмээс дэмжлэг авахдаа баяртай байдаг. Гэхдээ хүндрэлтэй асуудлууд ч бас байна. Багш нар хүний эрх болон эмзэг сэдвийг заахад амаргүй байдаг ч тэд цаашид хөгжих боломжтой гэдгийг ойлгож байгаа”.

”

³⁵ Киргизийн Засгийн газрын 2017-2022 онд хэрэгжүүлэх Терроризм, Экстремизмтэй тэмцэх хөтөлбөр. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/100104>

³⁶ Сурагчдад зориулсан «Мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс» сургалтын гарын авлага. <https://drive.google.com/file/d/1BKk8DOB3RY6gwyPVD2Sm9RuHWuiS899B/view?usp=sharing>

Залуучуудын Хөгжлийн Хүрээлэн мөн Киргизийн сургуулиудад албан бус иргэний боловсрол олгохоор ажилладаг.³⁷ Тэд “Сургуулийн сурагчдын иргэний чадавхийг хөгжүүлэх нь”³⁸ төслийн хүрээнд “хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийн загвар” боловсруулж байна. Одоо хэрэгжиж буй боловсролын хөтөлбөрөөс ялгаатай нь энэхүү хөтөлбөр нь сурагчдыг багшийн заавраар суралцахаас илүүтэй сургуулийн үйл ажиллагаанд ардчилсан зарчмаар идэвхтэй оролцох замаар суралцах боломжолгодог оролцооны арга барил руу шилжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Залуучуудын Хөгжлийн Хүрээлэн ТББ-аас “Залуусын Нээлттэй Парламент” төсөл хэрэгжүүлж байгаа ажээ. Уг төсөл нь залууст мэдээлэл боловсрол олгож, шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлэх замаар парламентийн ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх зорилготой юм.³⁹ Тус Хүрээлэнгээс мөн хүний эрхийн боловсролын үндэсний платформ болох “Укук” хэмээх залуусын албан бус сүлжээг хөгжүүлж байгаа бөгөөд “Хүний эрх ба Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаарх үндсэн курс”, “Хуулийн механизмын талаарх Ахисан шатны курс” болон “Хүний эрхийн сургагч багш нарт зориулсан сургалт” гэсэн гурван шат бүхий үндсэн сургалтын бүрэлдэхүүн хэсгүүдтэй.⁴⁰ Тус хүрээлэнгээс Киргизийн Боловсролын Академитай хамтран 7 дугаар ангийн “Хүн ба Нийгэм” хичээлийн сургалтын арга зүйг боловсруулж байна.

³⁷ Залуучуудын Хөгжлийн хүрээлэнгийн иргэний боловсрол болон Хөдөлмөр эрхлэлтийн талаарх үйл ажиллагаа. https://jashtar.org/kto-my/_/gallery/2.html

³⁸ Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийн загвар. <https://drive.google.com/file/d/1EZdEI3TXCApCS5MAEMdOvK4y03bdAhnQ/view?usp=sharing>

³⁹ Залуусын Нээлттэй Парламент төсөл. https://jashtar.org/kto-my/_/gallery/2/10.html

⁴⁰ «Укук» хүний эрхийн сургууль. <https://ukuk.jashtar.org/o-shkole.html>

5. ГОЛ ҮР ДҮН

Энэхүү зураглалын үр дүнд Киргизийн хүний эрхийн боловсролыг дэмжих ажиллуудад чухал ач холбогдолтой дараах дүгнэлт гараад байна.

1 Ерөнхий дүр зураг

- Киргиз улс олон улсын болон бүс нутгийн хэд хэдэн байгууллагын гишүүний хувьд хүний эрхийн боловсролын олон улсын хэм хэмжээг хангах үүрэг хүлээсэн. Эдгээрт ЭЗНСЭОУП-ын 13 дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 29 дүгээр зүйлд заасан хэм хэмжээнүүд багтана.
- Үндэсний хууль тогтоомж нь хүний эрхийн чанартай боловсрол олгохын ач холбогдлыг Боловсролын тухай хуулиар баталгаажуулсан байна.
- Сургалтын хөтөлбөрт хүний эрхийг “Хүн ба Нийгэм” хичээлээр олгож байгаа бөгөөд академик агуулгыг хичээлийн стандартын дагуу боловсруулж, практикт хэрэгжүүлж байна.
- Стандартад хүний эрхийг тэргүүлэх чиглэл гэж заасан бөгөөд суралцагчдад жендэрийн тэгш байдал, хүний эрхийн үнэт зүйлсийн талаар заах замаар тэднийг тасралтгүй өөрчлөгдөж буй дэлхий ертөнцтэйг дасан зохицох боломжийг олгодог. Түүнчлэн, стандарт нь уг сэдвийн хүрээн дэх үндсэн зарчмууд болон салбар хоорондын уялдаа холбооны талаар дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.
- Энэхүү хичээл нь өөрийнхөө талаар эргэцүүлэн бодох, нийгмийг танин мэдэх, тухайлбал, хүний бие махбод, оюун санааны онцлог, бусдын үнэт зүйлсийг ойлгож, хүндэтгэх чадвар зэрэг хувь хүний бусдаас ялгарах онцлог шинж чанаруудыг ухамсарлах чадваруудыг хөгжүүлдэг. Түүнчлэн, хүний эрхийг хамгаалах мэдлэг, практикийг үр дүнтэй ашиглах, иргэний үүргээ биелүүлэх, хүний эрхийг хүндэтгэх, соёлын ялгаатай байдалд хүлээцтэй хандах, орлого, зарлагаа төлөвлөх санхүү, эдийн засгийн ойлголт зэрэг иргэний болон эрх зүйн мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд чиглэгдэж байна.
- Зарим ТББ-ын ажилтнуудын үзэж байгаагаар Киргизийн БШУЯ нь хүний эрхийн боловсролын салбарт иргэний нийгэмтэй хамтран ажиллахад зарчмын хувьд нээлттэй.
- Киргизийн багшийн хөгжлийн хөтөлбөрт хүний эрхийн агуулга тусгагдсан, багшийн сургалтын байгууллагууд багш нарт чанартай сургалт явуулах чиглэлээр хамтран ажилладаг. Түүнчлэн, иргэний нийгмийнхэн орчин үеийн заах аргыг ашиглан хүний эрхийн боловсрол олгох талаарх багш нарын заах аргыг дээшлүүлэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

- Киргизийн иргэний нийгмийн байгууллагууд тодорхой мэргэжилтний нөөцтэй бөгөөд ТББ-ууд нь сургалтын хөтөлбөр, үнэлгээний систем боловсруулах болон багш нарт дэмжлэг үзүүлэх хангалттай чадвартай юм. Мэргэжлийн боловсролын лицей сургуулиудад хүний эрхийн боловсрол олгох төсөл эхэлж байгаа бөгөөд иргэний боловсролын төсөл ч мөн Бишкекийн хэд хэдэн сургуульд хэрэгжиж байна.

2 Тулгамдаж буй сорилт

- Хүний эрхийг заах сурах бичиг хангалтгүй.
- Иргэний нийгмийн байгууллагууд төсөлд суурилсан олон ажлыг хэрэгжүүлдэг бөгөөд байнгын санхүүжилт байхгүй тохиолдолд хэрэгжилт тасалдах эрсдэлтэй.
- Киргиз хэл дээр хүний эрхийн мэдээлэл, материал олох боломж хязгаарлагдмал.
- Жендэрийн тэгш эрх зэрэг хүний эрхийн тодорхой сэдвээр сургуульд зааж буй хичээлийг эцэг, эхийн зүгээс эсэргүүцдэг тал байна.

3 Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролыг сайжруулахын тулд үнэлгээ хийх шаардлага ба боломж:

- Иргэний нийгмийн бүлгүүдийн боловсролын салбарт хүний эрхийг дэмжих нөлөөллийн стратегийн ур чадварыг хөгжүүлэх, мөн энэ сэдвээр ганцаарчилсан болон хамтарсан нөлөөллийн стратеги боловсруулах асуудлаар тохиролцоонд хүрэх,
- Иргэний нийгмийнхэнд 5-11 дүгээр ангийн хүний эрхийн хичээлийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний систем, багшид үзүүлэх дэмжлэгийн агуулгыг боловсруулах талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх,
- 7-8 дугаар ангийн “Хүн ба Нийгэм” хичээлийн шинэ сурах бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хүний эрхийн мэргэжилтнүүд болон сурах бичиг зохиогчдыг сургах,
- Хүний эрхийг хамгаалах асуудлыг сургуулийн гол үнэт зүйл болгох өргөн хүрээтэй нөлөөллийн ажил явуулах, “Хүн ба Нийгэм” хичээлийн цагийг нэмэгдүүлэх талаар нөлөөллийн ажил явуулах,
- Хүний эрх, иргэний эрх үүрэг зэрэг сэдвийг заах багш нарын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Хүрээлэнтэй хамтран ажиллах шинэ арга зүй, хэрэглэгдэхүүн нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

- Хүний эрхийн боловсрол олгох цахим хэрэглүүр, эцэг эхтэй харилцах боломжийг олгох арга хэрэгслийг бий болгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх,
- Төв Азийн Боловсрол ба Хүний Эрхийн Сүлжээ (албан ба албан бус) байгуулах,
- Сургуулиудад хүний эрхийн боловсролыг төлөвшүүлэх үйл ажиллагаа, тэргүүн туршлага солилцох платформ бий болгох,
- Киргиз хэл дээр хүртээмжтэй, чанартай контент бүтээх, киргиз хэлтэй багш нарыг хүний эрхийн чиглэлээр сургах.



976 7000-4705



www.amnesty.mn



Amnesty International Mongolia -
Монголын Эмнести Интернэшнл



members@amnesty.mn



Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж,
#АВ центрийн 7 давхарт 701 тоот



Index: EUR 58/4120/2021
Date: APRIL 2021
amnesty.org